МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,124.617... ҮСХ-ны өгөгдлийн мэдээгээр

2017.01.04. Лхагва. №001 (4615) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

УЛС ТӨР

МАХН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙГ ЭСЭРГҮҮЦЭЖ БАЙНА ГЭВ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ШӨНИЙН ЦАХИЛГААНЫ ТАРИФ ТЭГЛЭХ ШИЙДВЭР ИРГЭДЭД ТААЛАГДЖЭЭ

V нүүрт

Дугаарын 60 мөр

Цэнгүүн хийж мөнгө үрэхээс татгалзаж болдог юм байна

Н.ПУНЦАГБОЛД

Хоёр он солигдох шинэ жилийн баярыг монголчууд бид цагаан сараасаа ч өргөн дэлгэр тэмдэглэдэг болоод удаж байна. Энэ жил ч гэсэн их сайхан, өргөн дэлгэр тэмдэглэлээ. Эдийн засаг хүндхэн байгаа, улс орон хямарсан, өр төлбөрөө төлөх гэж аргаа барж байгаа гээд буй ч баярлах цэнгэхдээ бол гар татахгүй л байгаа, манай дарга нар. Тийм ч баяр, ийм цэнгүүн гээд л хөвөрч, дарга нараа шагнаж, шилдэг гишүүн хүртэл тодруулж ч байх шиг. Яасан сайхан сэтгэл амар баярлаж чаддаг юм. Ёстой л сүх далайтал үхэр амар гэдэг шиг л байна. Гэхдээ олон дарга, гишүүн дотор санаа зовдог, иргэний төлөө сэтгэл зүрхтэй хүмүүс бас байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ХҮҮХЭД ЧИНЬ ӨВДСӨН БОЛ ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ АВЧ БОЛНО

Н.ПУНЦАГБОЛД

2017 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлээд нэлээд хэдэн хууль, журам хэрэгжиж эхлээд байгаа. Тэр дунд хүнд хэрэгтэй, ашигтай хууль, журам ч бий. Хэрэг болохоргүй хууль, журам ч хэрэгжиж эхэллээ. Тиймээс "Монголын мэдээ" сонин энэ оны эхнээс хэрэгжиж эхэлж буй хууль, журмыг танилцуулж байна. Тэр дунд маш хэрэгтэй нэг журам гарсан нь хүүхэд нь өвдсөн эцэг, эхчүүд таван хоногийн цалинтай чөлөө олгохоор болсон явдал юм.

Өвдсөн хүүхдээ асрахдаа цалинтай чөлөө авч болно

Улаанбаатар хотын агаарын бохирдол дээд цэгтээ хүрч, хүн амьдрахын эцэсгүй болчихоод байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

БАЙНГЫН ХОРОО

Хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар бөглөдөг болно

Ж.ОТГОН

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар "Хууль зүйн байнгын хорооны 2012 оны дөрөвдүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай" асуудлыг хэлэлцэж, баталлаа. Уг асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэх шаардлагагүй Байнгын хороо батлаад хэрэгжүүлэх эрхтэй байдаг байна. Ийнхүү тогтоолын төслийг баталсанаар Авлигатай тэмцэх газарт мэдүүлдэг хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг зэрэг мэдүүлгүүдийг цахимаар өгдөг боллоо. Түүнчлэн төрийн албан хаагчдын 50 хувь нь хөрөнгө орлогоо мэдүүлэхгүй байж болохоор болж байна. Тиймээс энэхүү шийдвэрийг эрх баригчид төрийн албыг төрлийн алба болгосон булхайгаа нуух хэрэгсэл хэмээн харах хүн цөөнгүй байгаа юм. Мөн энэ үеэр хувийн ашиг сонирхолын зөрчил гэдэг ойлголтыг оновчтой тодорхойлж эрх зүйн тодорхой өөрчлөлт хийх асуудал хөндөгдөж байлаа. Тиймээс тун удахгүй ашиг сонирхлын зөрчил гэдэг ойлголтыг өөрчлөх бололтой.

Тогтоолын төслийн талаар АТГ-ын дэд дарга Ц.Нямдорж танилцуулсан бөгөөд улсын хэмжээнд холбогдох хуулийн үйлчлэлд хамрагдах 38 мянга орчим албан тушаалтан хуульд заасан үндэслэлийн дагуу хувийн ашиг сонирхлыг мэдүүлэг /ХАСМ/ болон хөрөнгө орлогын мэдүүлгийг /ХОМ/ АТГ цахим систем буюу https://meduuleg.iaac.mn цахим хуудсаар бүртгэдэг байна.

Үргэлжлэл нь II нүүрт

ДЭЛХИЙ

ИСТАНБУЛЫН ХАЛДЛАГЫГ "ЛАЛЫН УЛС" БҮЛЭГЛЭЛ ЗАХИАЛЖЭЭ

Б.ДАВААХҮҮ

Туркийн Истанбул хотын шөнийн клуб руу зэвсэглэсэн этгээд халдаж, 39 хүний аминд хүрсэн хэрэг он солигдож, шинэ он гарсны дараа гарсан. Шөнийн 01:15 цагийн үед Рейна гэх шөнийн клубт 700 гаруй хүмүүс цуглан шинэ жилийн баяраа тэмдэглэж байхад буутай этгээд гэнэт халдаж, долоон минутад 120-180 удаа гал нээсний улмаас 65 хүн гэмтэж, мөн 30 гаруй хүн харамсалтайгаар амиа алдсан юм. Амиа алдагсдын ихэнх нь гадаад улсын иргэд байсан гэдэг. Орон нутгийн хэвлэлүүд эхэндээ санта клаусын хувцастай хоёр этгээд халдлага

үйлдсэн гэж мэдээлж байсан ч сүүлд салбар яамнаас албан ёсны мэдэгдэл хийхдээ нэг хүн үйлдсэн, мөн гэмт этгээд санта клаусын хувцасгүй байсан гэдгийг мэдэгдсэн байдаг. Түүнчлэн, эхэндээ энэ удаагийн халдлагыг хэн, ямар бүлэглэл үйлдсэн нь тодорхойгүй байсан юм. Туркид сүүлийн үед удаа дараа халдлага үйлдэж, олон хүний аминд хүрсэн Курдын хүчнийхэн ч уг хэрэгт оролцоогүй гэдгээ илэрхийлсэн.

Үргэлжлэл нь VI нүүрт

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2490.00	2497.00	ФУНТ	3010.00	3110.00
ЕВРО	2576.00	2643.00	РУБЛЬ	39.10	42.50
ИЕН	21.00	21.30	ЮАНЬ	356.00	359.90

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2485.00	2497.00	ФУНТ	3025.00	3119.00
ЕВРО	2576.00	2659.00	РУБЛЬ	39.16	43.58
ИЕН	20.95	21.61	ЮАНЬ	357.00	360.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ЦАХИМААР БӨГЛӨДӨГ БОЛНО

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Үүний зэрэгцээ давхар цаасан хэлбэрээр гаргуулан дөрөв дэх жилдээ ажиллаж байгаа гэв. Албан тушаалтнуудаас гаргаж буй ХАСМ, ХОМ-ийг цахим хэлбэрээр гаргуулан авснаар төрийн албан хаагчид интернэт бүхий орчинд хаанаас ч мэдүүлэг гаргах боломж бүрдэх юм байна. Ингэснээр улсын хэмжээнд нэгдсэн сан бүрдүүлэх, мэдүүлгийн хяналт шалгалтыг хуулийн хугацаанд шуурхай зохион байгуулах, ХОМ-т олон талын судалгаа, дүн шинжилгээ хийх, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зэрэг ач холбогдолтой гэлээ. 2012 оноос ХАСМ болон ХОМ-ийг цаасан хэлбэрээр авахаас бүрэн татгалзах зорилт тавьж ирсэн, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжих нөхцөл боломж хангалтгүй явж иржээ. Монгол Улсын хувьд цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх бүхий үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн түлхүүрийн нийтийн дэд бүтцийг бий болгон, үйлчлэх хүрээний хувьд төрийн нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх, дамжуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2011 оны арванхоёрдугаар сарын 15-ны өдөр Цахим гарын үсгийн тухай хуулийг баталсан хэдий ч 2016 онд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг аж ахуйн нэгжид олгожээ. Гэвч хуулийн хэрэгжилт хангалттай биш байгаа аж. Иймд одоогийн үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд мэдүүлэг гаргагч нь ХАСМ, ХОМ-ээ цахим бүртгэлийн программд оруулаад, баталгаажуулсны дараа хэвлэн, хуудас бүрт гарын үсэг зурж, тухайн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгнө. Үүний дараа АТГ-ын даргын 2012 оны 91 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан ХАСМ, ХОМ-ийг хүлээн авсан тухай бүртгэлд бүртгүүлэх буюу цахимаар болон цаасаар давхар хэвлэн өгдөг хэлбэрээр явж байгааг тэрбээр танилцуулгадаа дурдсан юм.

Өнөөдрийнбайдлаарцахимсанд 2013-2016 оны хооронд гаргасан 161831 ХАСМ, ХОМ бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр мэдүүлгийг ердөө хэвлэхэд л нийтдээ 90.9 сая төгрөг зарцуулсан талаарх тооцоолол гаргасан байгаа гэнэ. АТГ-аас ХАСМ болон хяналтын ажлыг цахимжуулахаар бэлтгэл ханган, дуусах шатандаа явж байгаа гэлээ. АТГ жилд дунджаар 10 мянга орчим иргэний ХАСМ-ийг хянаж, хариу хүргүүлдэг бөгөөд 2015 онд 14.4 сая төгрөгийн зардал гаргажээ. Цаашид ХАСМ болон ХОМ-ийг цахим хэлбэрээр бүртгэн, цаасан хэлбэрээр авахаас татгалзах нь төсвийн хөрөнгө хэмнэх, мэдүүлэг гаргагч болон бүртгэгч, хянагчийн цагийг хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой болохыг талаар АТГ-ын дэд дарга Ц.Нямдорж танилцуулгынхаа төгсгөлд онцолсон юм.

Хэлэлцүүлгийн шатанд гишүүдийн хэлсэн байр суурийг хүргэж байна.

УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:

- Хөрөнгө орлогын мэдүүлгийн /ХОМ/ тухайд Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор хэм хэмжээ маягийн юм тогтоосон шийдвэр гаргаж байгаа нь буруу. Учир нь энэ УИХ-ын тогтоолоор шийдэгдэх ёстой асуудал. Хууль зүйн байнгын хороонд хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрх байхгүй. Хэрэг дээрээ энэ асуудал чинь тогтоол нэртэй хууль маягийн юм болоод байгаа. Тиймээс та нар энэ удаад энэ тогтоолоо батлуулж авчихаад, дараа нь ХОМ-тэй холбоотой асуудлыг УИХ-аар шийдүүлэх төсөл санаачилж, батлуулах хэрэгтэй. Хэдий болтол дураараа авирладаг шийдвэрээр явах юм. Үүнийг би АТГ-ын асуудал хариуцсан хүмүүст хэлж байна шүү. Байгнын хороогоор асуудал шийдэж байгаа нь хууль бус. Учир нь Үндсэн хуульд УИХ хууль тогтоомж гаргана гээд заачихсан байдаг. Хаврын чуулганаар ХОМ-тэй холбоотой асуудлыг хэлэлцэхээр тооцож, явуулах хэрэгтэй.

УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:

-Маягтуудыг бүртгэх, хянах, хадгалах журамд өөрчлөлт оруулаад, нэлээн хөнгөвчилж, цаг хугацаа, цаас зардал хэмнэгдэх гэж байгаа юм байна. Ер нь АТГ байгуулагдсанаас хойш ХОМ авдаг болсон. Харин худлаа мэдүүлсэн бол хариуцлага хүлээлгэнэ гэсэн хэрнээ энэ тал дээр дорвитой хийгдсэн ажил байна уу. Шунал нь ихэдсэн төрийн албан хаагчидтай хатуу тэмцэх хэрэгтэй. Тиймээс энэ ажлын үнэлэлт, дүгнэлт хийх ажлыг жаахан эрчимжүүлмээр байна.

УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил:

-Энэ асуудлыг Ц.Нямдорж гишүүний хэлсэнээр УИХ-ын тогтоолын төсөл болгон батлуулаарай. Төрийн зарим өндөр албан тушаалтнуудад ашиг сонирхлын зөрчилтэй эсэх асуудлаар дүгнэлт гаргаж өгөөд байгаа. Тэгвэл сонгуулийн дараа Засгийн газар бүрэлдээд албан тушаалтнуудыг томилох үеэр харж байхад тэр салбарт ажиллаж байгаа хүн тухайн салбартаа ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа бол заавал ашиг сонирхлын зөрчилтэй байх ёстой юм шиг ойлголт нийгэмт төрүүлээд байна. Тиймээс энэ асуудал дээр АТГ-ынхан бодож, зарим тохиолдолд хуульд тодруулах зүйл байвал бидэнд саналаа оруулж ирж болно шүү. Зарим тохиолдолд та нар хүний нэрийг заалгүй ямар тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаагаа жишээ гаргаж хэлж болно. Тэгэхгүй бол албан тушаал нэр дэвшиж байгаа хүмүүс үүнийг мэдэхгүй байна. Тухайлбал, хувийн эмнэлэгтэй хүн эрүүл мэндийн салбарыг аваад явахад заавал ашиг сонирхлын зөрчил гэдэг ойлголтыг оновчтой тодорхойлох нь манайх шиг боловсон хүчний хязгаарлагдмал нөөцтэй улсад чухал. Тиймээс эрх зүйн тодорхой өөрчлөлт хийх шаардлагатай. Энэ хүрээнд АТГ-ынхан ажил хийгээд байгын хороонд нэг танилцуулаарай гэдэг хүсэлт байна.

УИХ-ын гишүүн Х.Нямбаатар:

-80 сая хүн амтай дэлхийн том гүрэн болох Герман улс гэхэд ердөө долоон мянган хүнийг урьдчилан сэргийлэх орчиндоо хянаж байдаг. Гэтэл манай улс хүн ам болон төрийн албаны бүтэц давхарга цөөн хэрнээ өнөөдөр бараг 40 мянга орчим хүнийг энэ бүтцээрээ хянадаг. Тиймээс ч АТГ-ын ачаалал хүндэрдэг зэрэг асуудал үүсч байгаа. Тиймээс маш богино хугацаанд ХОМ авдаг 38900 хүнээ 17300 болгох хэрэгтэй байна. Үүнтэй давхцаад бас нэг тоо орж ирэх ёстой. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар офшортой тэмцэх асуудал хуульчлагдах гээд явж байгаа. Тиймээс үүнтэй уялдуулж хамрах хүрээг нь бас уялдуулан ярилцаж нэн яаралтай хамтдаа орж ирэх ёстой. Үүнийг богино хугацаанд шийдээрэй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

АН гишүүдийнхээ бүртгэлийн хугацааг сунгахгүй

АН гишүүдийнхээ шинэчилсэн бүртгэлийг хийж байгаа. Тэгвэл намын шинэчилсэн бүртгэлд 18 мянган гишүүн хамрагдаж чадсан байна. АН-ын гишүүдийн шинэчилсэн бүртгэл баасан гараг буюу нэгдүгээр сарын 06-ны өдөр дуусна. Шинэчилсэн бүртгэлдээ хамрагдсан АН-ын гишүүд л намын даргын сонгуульд санал өгөх эрхтэй болох юм. Гишүүдийн шинэчилсэн бүртгэлийг сум, аймаг, дүүргийн намын хороо болон төв нам дээрээ хийж байгаа. Гишүүдийн бүртгэлийг сунгах эсэх талаар албаны хүнээс тодруулахад, “АН-ын 18 мянга орчим гишүүд нь шинэчилсэн бүртгэлдээ хамрагдах нь бага тоо. Гэхдээ гишүүдийнхээ шинэчилсэн бүртгэлийн хугацааг сунгахгүй” гэлээ.

Дотоод цэргийн ангиудыг дахин сэргээнэ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Дотоодын цэргийн тухай хуулийн төслийг арванхоёрдугаар сарын 22-нд өргөн барьсан. Хуулийн төсөл батлагдсанаар өмнө нь татан буугдаад байсан Дотоодын цэргийн ангиудыг дахин байгуулахаар болж байгаа юм. Хуулийн төсөл нь таван бүлэг, 40 зүйлтэй. Цагдаагийн албаны тухай хуулийг 2013 онд баталсанаар энэ хуулийн хүрээнд 1995 онд батлагдсан Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсон. Үүнийг дагаад дотоодын цэргийн ангиуд 2014 оны дөрөвдүгээр сарын 1-ээс татан буугдаж, Хилийн цэрэг, Цагдаагийн ерөнхий газрын харьяанд очсон юм. Дотоодын цэрэгт татагдаж байгаа шинэ цэргүүд галт зэвсэгтэй шууд харьцах эрх байдаг. Гэвч дөнгөж сурагчийн ширээнээс гарч ирсэн залуучууд галт зэвсэгтэй харьцаж байгаа нь учир дутагдалтай гэж үзсэн. Дотоодын цэргийн үндсэн үүрэг нь улсын онцгой объект хамгаалах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэнтэй холбогдуулан цагдаагийн бие бүрэлдэхүүнд хүч нэмэх хоёр үүрэгтэй. Тиймээс дотоодын цэргийн ерөнхий чиг үүргийг Хил хамгаалах газар, Цагдаагийн байгууллагын дэргэд байлгах боломжтой гэж үзсэн учраас Дотоодын цэргийн тухай хуулийг хүчингүй болгож байжээ.

MINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭЛЭЛ

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН: Нийтийн сонсголын хуулийг ”амь оруулах” цаг нь болсон

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцээд, 100 хувийн саналаар “Төслийг хэлэлцэх нь зүйтэй” хэмээн дэмжлээ. Үүний дараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийтийн сонсголыг зохион байгуулах журам батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг нэр бүхий гишүүд санаачлан боловсруулжээ. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан “Нийтийн сонсголын тухай энэ товчхон хуулийг ”амь оруулах” цаг нь болсон. Гэхдээ юм болгоноор нийтийн сонсгол хийнэ гэж татаж аваад байж таарахгүйг хаа, хаанаа бодолцож, төслийг нухацтай хэлэлцэх шаардлагатай шүү” гэсэн байр суурь илэрхийлсэн юм. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь “Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй” хэмээн үзсэн учраас чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар болж, шийдвэрлэснээр хуралдаанаа өндөрлүүллээ. Харин Өргөдлийн байнгын хорооны хуралдаан хуралдаанаар “Агаарын бохирдол ба Улаанбаатарын утаа” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг хэлэлцлээ. Хуралдаанд агаарын бохирдлын эсрэг ажиллаж байгаа албан байгууллагын төлөөлөл хүрэлцэн ирсэн юм. Өмнө нь зохион байгуулагдаж байсан хэлэлцүүлэг болон Байнгын хороон дээр яригдаж байсан тоо баримтаас дуулгахад, ДЭМБ-аас агаарын чанар муутай 50 хотыг нэрлэсөн бөгөөд жагсаалтын 47 дугаарт Улаанбаатар хот орсон байна. Улаанбаатар хотод агаарын чанарыг хянах 14 автомат станц байдаг бөгөөд агаарын бохирдлын хэмжээг өдөр бүр хэмждэг аж. Өнөөдөр Улаанбаатар хотын хэмжээнд РМ 2.5 жижиг тоосонцрын хэмжээ байх ёстой хэмжээнээс долоо дахин өндөр байна.

ШАРМЭДЭЭ

МАХН Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг эсэргүүцэж байна гэв

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын гишүүн О.Баасанхүү тэргүүтэй МАХН-ын гишүүд Ерөнхийлөгчийн сонгууль өргөн барьсантай холбогдуулан мэдээлэл хийлээ. УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль боловсруулах ажлын хэсэгт миний бие орохыг санал болгосон ч оруулаагүй. Энэ хуульд заасан хэд хэдэн заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж МАХН үзэж байгаа. Энэ хууль зөвхөн хоёрхон намд ашигтай хувилбар болсон. Тиймээс МАХН эсэргүүцэж байна” гэлээ. Үндсэн хууль зөрчсөн гэх заалтын тухайд 6.3-т “Дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан МонголУлсынуугуулиргэнЕрөнхийлөгчөөр сонгогдоно” гэсэн заалт нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын уугуул иргэн нь хаана ч амьдрах, чөлөөтэй зорчих, амьдрах бүрэн эрхтэй гэж заасан байдаг. Монгол Улсад амьдардаг байх ёстой гэж хуульд тусгаад, түүнийг нь Хил хамгаалах ерөнхий газраас баталгаажуулсан лавлагаагаар гэж заасан хууль зөрчиж байгаа гэнэ. Мөн 31.1.1.Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн нам дангаараа оролцоно. Монгол Улсад 21 нам байгаа. Намаар харьяалж байгаа нь нэр дэвшигчдэд саад хийсэн үйлдэл гэж МАХН үзэж байгаа юм байна. Заавал намын гишүүн байхаар хуульчилсан нь сонгогдох эрхээ эдэлж байгаа хүнийг аль нэг намд элсүүлэх шаардлага тавьж байгаа аж. Түүнчлэн 31.1.2.Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намууд хамтран гэж заасан нь хууль зөрчиж байна. Ганцхан суудалтай МАХН-ыг аль нэг намтай хүчээр хамтарч оруулах гэсэн санаатай байна гэв. Мөн 30.6 “Төрийн жинхэнэ албан хаагч Ерөнхийлөгчид нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна” гэж заасан ч энэ хууль өөрөө нэгдүгээр сарын дундуур батлагдах учраас мөрдөх боломжгүй гэлээ. Харин 30.4.Улсын Их Хуралд суудалгүй нам Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг дэмжиж болно. Энэ заалт нь сонгуульд оролцохгүй байж болно гэсэн санаа байна. Улстөрийн намууд бусад намын нэр дэвшигчийг дэмжихээс өөрөөр хамтрах боломжгүй гэж заасан нь хууль зөрчсөн гэж үзэж байгаа ажээ.

ҮЗЭЛ БОДОЛ

ХҮҮХЭД ЧИНЬ ӨВДСӨН БОЛ ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ АВЧ БОЛНО

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэвч монголчуудбидаажмаар “үхэж” буйгаа мэдрэх ч завгүй ажиллаж, амьдарсаар. Хүйтний улирал эхлэхээр л бага насны хүүхдүүдийн ханиад томуу дийлдэхээ больж, эмнэлгүүдийн ачаалал дээд цэгтээ тулдаг. Сүүлийн 2-3 жил бага насны хүүхдийн ханиад томуу улам хүндэрч, уушигны хүнд хатгалгаа болж хувирч, бүр амь насаа алдаж байгаа. Эцэг, эхчүүд хүүхдээ асарч, сувилах, эмнэлэгт хэвтэх болохоор ажлаасаа чөлөө авдаг. Жаахан яхир даргатай бол бараг л ажлаасаа гарч байж хүүхдээ асрах дээрээ тулж байсан. Тэгвэл Засгийн газраас энэ асуудлыг зохицуулж, энэ сарын 2-ны өдрөөс ирэх гуравдугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд тав хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт болон гэртээ 3-5 хоног асарсан эцэг, эхэд цалинтай чөлөө олгохоор болсон. Мөн энэ шийдвэрийн дагуу өрхийн эмнэлгүүд ч бямба гараг бүр цагийн хуваарийн дагуу ажиллахаар болоод байгаа. Ханиад хүрсэн бага насны хүүхдүүдийг гэрт нь харах хүнгүйн улмаас эмчилгээгээ дуусгалгүй, эсвэл сургууль, цэцэрлэгтээ явангаа эмээ уух нь эмчилгээний үр дүн багатай байгаа юм. Мөн ханиадаа дутуу эдгээснээс болж хүндэрч, хатгалаа болж, амь насаа алдах эрсдэлтэй ч нүүр тулж байгаа. Ийм үед эцэг, эх гэртээ хүүхдээ ажлын тав хоног, цаашлаад долоо хоног асраад, эмчилбэл ядаж л ханиад нь хүндэрч, хатгаа болох эрсдэл дагуулахгүй шүү дээ. Ямар ч байсан Засгийн газрын журам хэрэгжиж эхэллээ, гуравдугаар сарын 1 хүртэл үргэлжилнэ. Эцэг, эхчүүд ханиадтай хүүхдээ сайтар асарч ав, энэ хугацаанд.

Цалин нэмэгдэхгүй ч торгууль нэмэгдэнэ

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутамд нэг удаа шинэчлэн тогтоодог хуулийн зохицуулалтай. Хамгийн сүүлд буюу 2013 оны есдүгээр сарын 1-нд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэж 192 мянган төгрөгт хүрсэн. Харин өнгөрсөн дөрөвдүгээр сарын 20-нд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороон хуралдан тогтоол баталж 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 хувиар нэмж 240 мянган төгрөг болгохоор шийдвэрлэсэн юм. Ингэснээр энэ сарын 1-нээс цалингийн доод хэмжээ нэмэгдлээ. Үндсэн цалингаа доод хэмжээгээр авч, нийгмийн даатгал төлдөг. Ихэнх цалин нь урамшуулал маягаар олгогддог хүмүүсийн үндсэн цалин нь нэмэгдэж байгаа байх. Түүнээс өөрөөр цалингийн доод хэмжээ нэмэгдсэнээр иргэдэд ашигтай юм болсонгүй. Ингэлээ гэвч цалин нэмэгдэхгүй. Өмнө нь цалингийн доод хэмжээ нэмэгдэхтэй зэрэгцээд төрийн байгууллагууд цалингаа тодорхой хувиар нэмдэг байлаа. Төрийн байгууллагаа дагаад хувийн аж ахуйн нэгжүүд ч цалингаа бага сага нэмдэг байсан. Тэгвэл энэ жил эдийн засгийн хямралтай, гадаад өр төлөх учраас төрийн байгууллагууд цалингаа нэмэхгүй. Төрийн байгууллагын цалин нэмэгдэхгүй байхад хувийн хэвшлүүд юу гэж цалингаа өсгөх билээ. Харин цалингийн доод хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулаад бүх мөнгө торгуулиуд нэмэгдэж байна. Угаасаа цалингийн доод хэмжээний тэдэн хувьтай тэнцэх мөнгө гэж торгодог. Тиймээс бүх торгууль нэмэгдэж таарах нь. Өөрөөр хэлбэл, 25 хувиар нэмэгдэж байгаа юм. Жолооч нар дүрэм зөрчсөнийхөө төлөө цалингийн доод хэмжээний 10 хувь буюу 19200 төгрөгөөр торгуулдаг байлаа. Тэгвэл одоо 24 мянган төгрөг өгөх юм. Цаашлаад, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 384 мянга байсан бол 480 мянган төгрөг болж өснө. Харин согтуугаар давтан жолоо баривал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ 768 мянга байсан бол 960 мянган төгрөгийн торгууль төлнө. Ганц замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийн торгууль бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр дүйцүүлдэг бүх торгуулийн хэмжээ дээр дурдсан шиг өөрчлөгдөнө. Тэгэхээр юуны өмнө жолооч нарыг дүрмээ ягштал баримтлахыг сануулъя.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгсэдтэй тэмцэх хатуухан хууль хэрэгжиж эхэллээ

Шинэ оны эхний өдрөөс зүрх зүсэгдэм мэдээ монголчуудыг сэрдхийлгэж, зэвүү дургүй хоёрыг нь зэрэг хүргэж байгаа. Тэр нь Хятадын иргэн гэрлэсэн монгол эмэгтэйгээ болон дагавар хүүхдүүдээ заазуурдаж, амь насыг нь хөнөөсөн хэрэг. Дөрөвхөн настай хүүг заазуурдаж, мал нядалж байгаа юм шиг авирласан Хятад иргэний гарт ээж нь ч бас амиа алдсан. Монголд гэр бүлийн хүчирхийллийг хэн дуртай нь үйлдэж, заазуур эргүүлж байгаагийн нэг жишээ энэ. Тэгвэл энэ сарын 1-ний өдрөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэлээд хатуу заалттай хууль хэрэгжиж эхэллээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох хуулийн төслүүдийг өнгөрсөн арванхоёрдугаар сарын 22-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан. Улмаар энэ сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэллээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сурталчлаад, энэ талаар сургалт мэдээлэл явуулаад байхад зөрчил гаргасан анхны тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Харин удаа дараагийн үйлдэл гаргавал үүнийг гэмт хэрэг гэж үзэн албадах буюу холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Түүнчлэн уг хуулиар эхнэр нөхөр, үр хүүхдийн хоорондын харилцааг зохицуулах төдий бус хамтран амьдрагчид, салсан гэр бүлийн асуудлыг ч хөндөж хамрах хүрээг нь өргөжүүлсэн. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн талаархи мэдээллийн сувгуудыг тэлэх, тэр дундаа хөршийн үүргийг тодорхойлж, удаа дараагийн гэмт үйлдлийг мэдээлээгүй айл хөршид хариуцлага тооцохоор болсон. Цаашлаад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, хамтарсан баг хэрхэн ажиллах бүх зохицуулалтыг тодорхой болгожээ. Тиймээс та гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, тийм үйлдэл үзүүлдэг бол хатуухан хууль хэзээ нэг өдөр гэсгээнэ гэдгийг сануулъя.

Зарим аж ахуйн нэгжийн татвар буурна

2017 оны нэгдүгээр сарын 1-нээс эхэлж хэрэгжиж байгаа нэг сайхан хууль байгаа. Тэр нь аж ахуй нэгжийн орлогын албан татварыг бууруулах тухай хууль. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2016 оны хоёрдугаар сарын 5-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг хуулийн өөрчлөлтийн дагуу зарим аж ахуйн нэгжийн татвар буурах юм. Тодруулбал, тус хуулийн 19.12-т заасны дагуу Улаанбаатар хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд байгсан үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 50 хувиар буурна. Мөн Улаанбаатар хотоос 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд үйл ажиллагаа явуулж буй аж нэгжийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлөх юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлт 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Гэвч Улаанбаатар хотоос 550 болон 1000 км-ээс хол зайд үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж дээрх татварын хөнгөлөлтөд хамрагдахгүй. Учир нь, хуульд үйл ажиллагааных нь чиглэлийн дагуу татварын хөнгөлөлтөд хамруулахгүй аж ахуйн нэгжүүдийг тусгайлан зааж өгсөн юм. Тодруулбал, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, согтуурруулах ундаа худалдах, импортлох, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх, авто бензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох, ярианы үйлчилгээ эрхлэх, эрчим хүчний эхүүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, түгээх, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх, автозам, замын байгууламжийг барих, засварлах, цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлийн үйлажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж татварын хөнгөлөлтөд хамрагдахгүй. Мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын энэхүү хөнгөлөлт нь хоёр жил буюу 2019 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр хүртэл үйлчлэх юм.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

Цэнгүүн хийж мөнгө үрэхээс татгалзаж болдог юм байна

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тухайлбал, Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут Засаг даргын нэрэмжит “Шинэ жилийн баяр”-ын хүлээн авалтыг хийлгүйгээр түүнээс хэмнэсэн мөнгөөрөө 10 гэр худалдан авч гэнэтийн гамшиг ослын үед орон гэргүй болсон өрх гэрт гэр бэлэглэсэн байгаа юм. Нэг орой ууж идээд, согтоод өнгөрөх 20 сая төгрөгөөр ийм буянтай ажил хийж, 10 өрхөд аз жаргал бэлэглэж. Өнөө “Орос шиг л бай л даа” гэдэг шиг манай дарга нар яагаад Д.Батлут дарга шиг байж болдоггүй юм бэ, энэ чинь. УИХ-ын гишүүдийн шинэ жилийг хийхгүй байж болно, тухайлбал. Нэг аймгийн Засаг даргын нэрэмжит шинэ жилийг тэмдэглэхгүй байхад 20 сая төгрөгийн зардал хэмнэж болж байна. Тэгвэл УИХ-ын гишүүдийн шинэ жилийг тэмдэглэхгүй өнгөрөөхөд үүнээс 10 дахин их мөнгийг хэмнэж болох байх, хамгийн багаар тооцоход. Тэгвэл тэр хэмжээний мөнгөөр эмнэлэгт өвчиндөө шаналж байгаа үрсээ эдгээхэд зориулж хөрөнгө оруулалт хийсэн ч яах вэ дээ. Өнөөдөр манай улсад юу их байна, асуудал л дүүрчихсэн. Шийдвэрлэх, шийдэх асуудлаас их юм алга. Монгол Улсын Засгийн газрын гишүүд, УИХ-ын түшээдэд шинэ жил тэмдэглээд, баярлаж суух зав байгаа бил үү. Юунд ч санаа зовохгүй ууж идэх эрх бий бил үү. Уг нь үгүй. Харин манай дарга нар улс орноо боддоггүй, амин хувийн жаргалаасаа хальж чадахгүй байгаа учраас ингээд л баярлаад сууж байна. Тэгээгүй бол ганц жил нийлж шинэ жилдэхгүй байхад яах вэ дээ. Тэр дундаа эдийн засгийн хямралтай үед нэг их баярлаад байх эрх байхгүй. Нийслэлийн удирдлагууд ч гэсэн хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй гээд байгаа мөртлөө л баяр ёслол, найр наадамд гар татахгүй цацаж байна. Энэ жил “Улаанбаатарын мөнгөн үдэш” гэсэн цэнгүүн хийгээд, төв талбайд тайз засч, баахан дуучин дуулуулсан. Никитон, Камертон талбайд тоглоход тус бүртээ 50 саяыг авсан.

Тэрэнтэй адил хөхөө хөвлийн хүйтэнд дуулах гэж оролдсон хэдэн хамтлаг, дуучид. Хөтөлж байгаа нэртэй хашгичсан нөхөд тодорхой хэмжээнд мөнгө авсан л байж таараа. Дахиад хэдэн зуун саяыг үрэн таран хийснийг бүү мэд. Эдийн засгийн хямралтай, гадаад өр төлбөр төлөх гэж байгаа энэ үед ганц удаа шинэ жилийн цэнгүүн хийхгүй байлаа гээд дарга нарын нэр хүнд унаад баларна гэж бодохгүй байна. Харин ч ард иргэд дэмжинэ, талархана, бахархана. Айл ч гэсэн орлого мөнгө муутай бол овлигогүйтээд л, зээл аваад шинэ жил хийгээд байдаггүй биз дээ. Боломж бололцоогоороо хэдэн жигнүүр бууз хийгээд, телевизээ үзээд, оргилуун дарсаа буудуулаад он гаргачихдаг. Монгол Улс ч гэсэн нэг байл. Гэхдээ маш их өртэй, орлого багатай, үр хүүхдээ тэжээж чадахгүй дээрээ хүрчихсэн, хоосон хонох шахаж байгаа айл. Ийм айл байгаа хэдхэн төгрөгөөрөө баяр хийгээд дуусвал юу болох билээ. Түүний оронд арай өөр зүйлд зарцуулж байж амьдарна биз дээ. Нэг дарга ийм сайн сайхан санаачилга гаргаж болоод байна. Бусад нь яагаад болохгүй гэж. Ядахын мууд С.Жавхлан гишүүн шиг ч болов бай л даа, энэ чинь. Айлд цалингаараа толгой шийр, гэдэс авч өг гэж байгаа юм биш. Зүгээр л шинэ жилийн цэнгүүнд оролцохоосоо татгалзчих л хэрэгтэй юм.

СУРТАЛЧИЛГАА

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины
I улирлын
нэмэлт захиалга
үргэлжилж
байна

Улиралд 44 дугаар

захиалгын үнэ
19800

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

ШӨНИЙН ЦАХИЛГААНЫ ТАРИФ ТӨГЛӨХ ШИЙДВЭР ИРГЭДЭД ТААЛАГДЖЭЭ

Б.ДАВАА

Монгол Улсын Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн гэр хорооллын айл өрхийн ахуйн болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувь хөнгөлсөн билээ. Шөнийн тарифыг оройн 21.00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл тэглэх бөгөөд энэ оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс ирэх дөрөвдүгээр сарын 1 хүртэлх хугацаанд үргэлжлэх юм. Тэгвэл энэ талаар албаны хүмүүс болон иргэд ямар байр суурьтай байгааг сонирхлоо.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

Улаанбаатар хот

2016 оны 12 сарын 28 өдөр Дугаар 248

Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын 2.1, 2.2 дах заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших 2 тарифт тоолууртай гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф, орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны хэрэглээнд тооцох сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 100 хувиар хөнгөлөхийг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлт үзүүлэх нэг сарын хэрэглээний дээд хязгаарыг 220 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 700 кВт.цаг, 380 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500 кВт.цаг байхаар тус тус тогтоосугай.

3. Цахилгаан шугам сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, айл өрхөд цахилгааны ашиглалтын аюулгүй байдалтай холбоотой сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулалтын газар /З.Цэдэнжав/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

А.Тлейхан: Хоёр тарифтай тоолуур тавьж байж, хөнгөлөлт эдэлнэ

/Эрчим хүчний зохицуулах хорооны дарга/

-Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын санаачилгаар Улаанбаатар хотын гэр хорооллын шөнийн хэрэглээний цахилгааны тарифыг тэглэх асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлж байна. Нийслэлийн гэр хорооллын 146 мянган хэрэглэгч бий. Эдгээр өрхөд хөнгөлөлт үйлчлэх юм. Гэхдээ гэр хорооллын өрхийн оройн 21:00-06:00 цагийн хооронд ашигласан цахилгааныг тэглэж буй учраас заавал хоёр тарифтай тоолуур тавих шаардлагатай болсон. Гэр хорооллын өрхийн 110 мянга орчим нь хоёр тарифтай тоолуур ашиглаж байгаа. Тэгэхээр үлдсэн 30 гаруй мянган айл өрхийн тухайд хоёр тарифтай тоолуур тавьж байж, хөнгөлөлт эдлэх боломжтой болно гэсэн үг. Стандартын тоолуур нь УБЦТШС болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудад худалдаалж байгаа. Хэрэглээний хувьд 380 вольт цахилгаан хэрэглэдэг айлууд 1500 кВт, 220 вольтын цахилгаан хэрэглэдэг айлууд 700 кВт-ын чадлын дээд хязгаар тогтооно. Учир нь хэрэглэгчдийн хэрэглэж буй цахилгаан дамжуулах утасны нэвтрүүлэх чадалтай холбоотой. Цахилгааны аюул, эрсдэлээс хамгаалсан арга хэмжээ гэж ойлговол зохино. Өмнө нь арваннэгдүгээр сарын 1-нээс эхлэн бүх айл өрх цахилгааны 50 хувийн хөнгөлөлт эдэлдэг байсан бол нийслэл хотын гэр хорооллын өрхүүд нэгдүгээр сарын 1-нээс дөрөвдүгээр сарын 1-ний хооронд 100 хувийн хөнгөлөлт эдлэх боломжтой болж байна. Ингэснээр нэг талдаа утааны хэмжээ багасна, нөгөө талдаа гэр хороололд амьдарч буй өрхийн зардал тодорхой хэмжээнд буурна гэж үзэж байгаа. Нэг зүйлийг онцлоход, энэ удаа гэр хорооллын өрхийн хэрэглээний цахилгааныг тэглэсэн. Цахилгааны тарифыг тэглэчихлээ гээд янз бүрийн үйлдвэрлэл үйлчилгээ явуулж болохгүй. Үүнээс болоод цахилгааны утасны ачаалал ихэсч аливаа эрсдэл гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Д.Бассайхан: Хоёр тарифт тоолуур 80-85 мянган төгрөгийн үнэтэй байгаа

/Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч/

-Зөвхөн ахуйн зориулалтаар буюу оршин суугаа орон байраа халаах зорилгоор хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тарифыг тэглэх асуудал л яригдаж байгаа. Түүнээс бус гэр хороололд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газруудын тухайд УБЦТШСК-тай аж ахуйн гэрээтэй учраас хамрагдахгүй. Хэрэв нууцаар энэ мэт үйл ажиллагаа явуулбал УБЦТШСК-ийн ажилтнууд зөрчил дутагдлыг илрүүлж, таслан зогсоох ёстой. Гэр хорооллын 146 мянган айл өрхийн 110 мянга нь ахуйн зориулалттай хоёр тарифт тоолууртай. Үлдсэн хэрэглэгчид нэг тарифтай тоолуур хэрэглэдэг. Тэгэхээр хоёр тарифтай тоолууртай хэрэглэгчдийн шөнийн цахилгааны тариф 100 хувь тэглэгдэнэ. Тиймээс бүх өрх хоёр тарифт тоолуур хэрэглэх шаардлагатай. Энэ асуудлыг УБЦТШС компани хангаж ажиллана. Нэгдүгээр сарын 1-нээс эхлэн гэр хорооллын иргэдийн шөнө хэрэглэсэн цахилгааны тариф тэглэгдэнэ гэсэн үг. Тоолуурын хувьд УБЦТШС компаниудын тоолуурын лабораториудад хоёр тарифт тоолуур 80-85 мянган төгрөгийн үнэтэй байгаа. Халаалтын зориулалтын 380 вольтын тоолуурын тухайд өөр өртгөөр зарагддаг.

М.Дунгармаа: Цахилгааны утас нь ачааллаа дийлэхээ болих вий

/Сүхбаатар дүүргийн долдугаар хорооны иргэн/

-Өвлийн хүйтэнд даарч, нүүрс түлж буй гэр хорооллын иргэдийн шөнийн цахилгааны тарифыг тэглэж буй нь маш зөв алхам. Гэхдээ утасны даацын хэмжээ гэж бий. Гэр хорооллын өрхүүд нэг шугамнаас хоёр ч айл салаалж авсан харагддаг. Шөнийн цахилгааны тарифыг тэглэснээр айл өрхүүд мэдээж цахилгаан халаагуур хэрэглэж таарна. Ингэснээр цахилгааны утас нь ачааллаа дийлэхгүй гал түймрийн аюул гарах вий гэдгээс болгоомжлох хэрэгтэй. Нөгөө талаар, тарифыг тэглэлээ гээд заавал тоолуураа соль, цахилгаан халаагуур хэрэглэ гэх мэтээр дарамт үзүүлэх хэрэггүй байх. Өвлийн хэрэглээний нүүрсээ бэлдчихсэн, мөнгөгүй байхад нь халаагуур хэрэглэ гээд байвал өрхөд дарамт болно. Үүсч болзошгүй асуудлыг бодолцон үзэж, зөв менежмент хийх шаардлагатай байх. Ер нь агаарын бохирдлыг бууруулах тал дээр иргэн бүхэн идэвхи чармайлт гаргах хэрэгтэй. Шинээр байшин барьж буй бол шалны халаалт тавьчих хэрэгтэй шүү дээ. Манайх Сүхбаатар дүүргийн долдугаар хороонд амьдардаг. Яг л утааны бүсэд амьдарч байна. Өглөө, оройдоо их л утаатай байх юм.

Н.Алтаншагай: Иргэддээ ойр шийдвэр болсон

/Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн/

-Манайх Чингэлтэй дүүргийн арвандолдугаар хорооны нутагт амьдардаг. Агаарын бохирдол их. Гэхдээ уулын орчимдоо харьцангуй гайгүй байдаг юм. Манайх харьцангуй бага бохирдолттой хэсэгт байдаг юм. Гэрт амьдардаг учраас нүүрс түлдэг. Галаа түлээд л гэр дулаацчихна. Засгийн газраас цахилгааны шөнийн тарифыг тэглэсэн нь илүү иргэддээ ойр шийдвэр болсон болов уу гэж бодож байна. Мэдээж, 100 хувь төлбөрийг тэглэж байгаа учраас боломж гарвал шалны халаалт хэрэглэнэ гэсэн бодолтой байгаа.

Ч.Баттөр: Нүүрсээ арай гэж авч байгаа айл өрх цахилгаан халаагуур авч хэрэглэнэ гэж байх уу

/Чингэлтэйн арвандолдугаар хорооны иргэн/

-Өчигдөр зурагт үзэж байхад нэгдүгээр сарын 1-нээс шөнийн цахилгааны тарифыг тэглэх талаар ярьж байсан. Энэ сарын цахилгааны төлбөр бичигдсэний дараа үнэхээр тэглэсэн эсэх нь мэдэгдэх байх. Гэхдээ цахилгааны шөнийн тарифыг тэглэлээ гээд гэр хорооллын бүх иргэд гал түлэхээ болино гэвэл үлгэр шүү дээ. Гэр хорооллын айл гал түлэхгүй байна гэж юу байх билээ. Цахилгаан халаагуур хэрэглэнэ гэдэг худлаа байх. Нүүрсээ арай гэж авч байгаа айл өрх цахилгаан халаагуур авч хэрэглэнэ гэж байх уу. Гал түлэхээ больж, цахилгаан халаагуур хэрэглэе гэж бодъё. Мэдээж, 24 цаг залгах хэрэг гарна. Гэтэл цахилгааны төлбөр нүүрс түлснээс бага гарна гэж байхгүй. Өмнө нь ч гэсэн цахилгааны төлбөр хөнгөлнө гэж ярьж байсан. Гэтэл хоёр айл нийлээд сардаа 40 мянгыг төлдөг байсан бол одоо дангаараа нэг айл 40 мянгыг төлж байгаа шүү дээ. Надад бол ялгаагүй санагддаг. Шөнийн цахилгааны тарифыг тэглэсэн ч гал түлэхээ болино гэж байхгүй. Миний бодол ийм л байна.

Г.Чулуунбаатар: Тоолуурны үнийг хямдруулбал зүгээр байх юм

/Баянзүрх дүүргийн тавдугаар хорооны иргэн/

-Би Баянзүрх дүүргийн тавдугаар хороонд амьдардаг. Өглөө, оройдоо утаа ихтэй. Хүн л болсон хойно хэн хүйтэнд даарч, үнс тортогтой ноцолдоё гэж бодох вэ дээ. Мэдээж, цахилгааны тарифны хөнгөлөлтийг төр засгаас үзүүлбэл цахилгаан халаагуур хэрэглэе гэсэн бодол байдаг. Манайх одоо нүүрс л түлж байгаа. 100 хувь хөнгөлөлт эдлэхийн тулд хоёрт тарифт тоолуур тавина гэсэн. Манайх тийм тоолуур аваагүй, хуучинтайгаа л байгаа. Уг нь нэгэнт шөнийн хэрэглээний тарифыг тэглэж байгаа юм чинь тоолуурны үнийг хямдруулбал зүгээр байх юм. Үнэ нь хямдраад эхэлбэл, манайх ч гэсэн шинэ тоолуур авъя гэж бодож л байна. Одоо нэг шонд гурав, дөрвөн айлын цахилгааны утас залгаатай байдаг. Сардаа тогны мөнгө 20 мянгаас дээш гардаг. Их байна. Тариф тэглээд эхэлбэл гайгүй болох байх. Засгийн газраас ийм шийдвэр гарсныг зөв гэж бодож байна. Айлууд ч гал түлэхээ болиод цахилгаан халаагуур хэрэглээд эхлэх болов уу.

ДЭЛХИЙ

Шоронд үймээн гарч, 56 хүн амь үрэгдлээ

Бразилын Амазонас мужийн Манаус хотын шоронд энэ сарын 1-ний өдөр томоохон хэмжээний үймээн дэгджээ. Тус шоронд ял эдэлж байсан ялтнууд хоорондоо зодолдож, үүний улмаас нийтдээ 56 хүн толгойгүй хирчүүлсэн байдалтайгаар амиа алдаж, 144 ялтан оргосон байна. “Анисио Иобим” гэх шоронд болсон тус үймээн үдээс хойш эхэлж, шөнө дунд хүртэл нийтдээ 17 цагийн турш үргэлжилсний эцэст намжсан байна. Албаны эх сурвалж нас барагсдын тоог эхэндээ 60 хэмээн дамжуулж байсан ч, дараа нь 56 хүн алагдсан хэмээн залруулсан юм. Өмнө нь тус мужийн шоронд ийм тооны хүн амиа алдсан тохиолдол гарч байгаагүй ажээ. Нэг үгээр хэлбэл, энэ удаагийн тохиолдол түүхэн дэх хамгийн олон ялтан ял эдэлж байхдаа нэг дор амиа алдсан тохиолдол болж байна. Мөн шоронгийн барилгаас олон тооны ухсан хонгил олджээ. Шоронгийн барилгын гадна зогсох зэвсэглэсэн цагдаагийн ажилтнууд тэдгээр хонгилоор дамжин ялтнууд оргосон ул мөрийг илрүүлсэн байна. Ингээд нийтдээ 112 ялтан оргосныг тогтоожээ. Мөн ойролцоо байрлах шоронгоос ч гэсэн тус үймээний үеэр 72 хүмүүжигч оргосон ч тэдний 40-ыг нь баривчилсан аж. Мөн түүний ярьснаар, 592 хоригдол байрлах ёстой энэ шоронд 1224 хоригдол байсан аж. Энэ шоронгийн үйл ажиллагааг хувийн компани эрхлэн явуулдаг бөгөөд шоронд хэчнээн хоригдол байгаагаас хамаарч улсаас тус компанид мөнгө олгодог байна. Үймээний явцад шоронгийн 12 хуягийг хоригдлууд барьцаалсан боловч хуягууд ямар нэг шарх, гэмтэлгүйгээр мултарч чаджээ.

Сельфи хийх гэж байгаад матарт хазуулжээ

Тайландын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд сельфи хийх гэж байсан залуу амиа алдах дөхжээ. Францаас Тайландад аялахаар ирсэн 47 настай эмэгтэй ухаалаг утсаа ашиглан тус хүрээлэнгийн матартай хамт зургаа авхуулах гэж байгаад халдлагад өртөж, хөлөө хазуулан хөнгөн гэмтэл авсан байна. Энэ явдал нийслэл Бангкок хотоос хойш машинаар гурван цаг орчим явж хүрэх зайд байрлах Хао Яй Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд болжээ. Тус газар нь ширэнгэн ойд явган алхах, хүрхрээ зэргээрээ жуулчдын дунд нэлээд алдартай гэнэ. Тэгвэл нэрээ нууцлахыг хүссэн хүрээлэнгийн ажилтны “франц пресс” агентлагт ярьснаар хохирогч эмэгтэй жижиг горхины эрэг дээр хэвтэж байсан матартай хамт сельфи хийхийг оролдjoжээ. Гэвч матар цочиж, бүсгүйн хөлийг хазсан байна. Эмэгтэйн хазуулсан тухайн хэсэгт хоёр матар амьдардаг аж. Тиймээс анхааруулах самбарыг ч хатгасан байжээ. Тус ажилтны хэлж буйгаар жуулчин эмэгтэй жинхэнэ матар гэж мэдээгүй байж магадгүй гэнэ. Халдлагын дараа эмэгтэй тэр даруй эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд азаар шарх нь хөнгөн байжээ.

ИСТАНБУЛЫН ХАЛДЛАГЫГ “ЛАЛЫН УЛС” БҮЛЭГЛЭЛ ЗАХИАЛЖЭЭ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Тэгвэл энэ сарын 2-нд Ирак, Сири дэх нөлөөллөө алдаж буй хэт даврагч “Лалын улс” бүлэглэл Истанбулд болсон халдлагын захиалагч гэдгээ хүлээж, тус бүлэглэлийн ариун дайчин үйлдсэн гэж мэдэгдсэн юм. Хэрэг гарах үед гэмт хэрэгтэн ч мөн зуттаж амжжээ. Одоогоор Туркийн цагдаагийн байгууллагынхан өргөн хүрээнд эрэн сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа ч террорист халдлага үйлдэгчийг олоогүй байна. Түүнтэй холбоотой тодорхой мэдээлэл ч байхгүй бөгөөд албаныхан гэмт этгээдийн хуурууны хээ, хэргийн газарт үлдээсэн баримт зэрэгт үндэслэн хэн болохыг нь тогтоохоор ажиллаж буй ажээ. Тиймээс хууль хяналтынхны хувьд эхлээд гэмт хэрэгтнийг таних, дараа нь хэнтэй хамтардаг болохыг нь, мөн түүний ард ямар бүлэглэл байгааг олж илрүүлэх гэсэн үүрэг даалгавар ногдож байгаа юм. Гэхдээ хэрэгт оролцсон гэх үндэслэлээр 12 хүнийг баривчилсан гэх мэдээлэл бий. Энэ талаар тус улсын шадар сайд Нуман Куртулмус сэтгүүлчдэд мэдээлсэн байдаг. Нөгөөтэйгүүр, Туркийн өдөр тутмын нэгэн сонинд халдлага үйлдэгч Төв Азийн Киргиз эсвэл Узбекистаны иргэн байж магадлалтай гэж цагдаагийнхан таамаглаж буй талаар нийтэлжээ. Хэрэг гарсны дараа шөнийн клубаас зуттаж буй хэрэгтний дүрс хяналтын камерт бичигдсэн байх бөгөөд түүний зургийг ч олон нийтэд дэлгээд байна. Энэ удаагийн халдлагаар амь үрэгдсэн хүмүүсийн дийлэнх нь гадаадын иргэд байгаа юм.

> ...Хэрэг гарсны дараа шөнийн клубаас зуттаж буй хэрэгтний дүрс хяналтын камерт бичигдсэн байх бөгөөд түүний зургийг ч олон нийтэд дэлгээд байна...

Тодруулбал, Саудын Арабын долоо, Ливаны гурав, Иракийн гурав, Энэтхэгийн хоёр, Иорданы хоёр, Мороккогийн хоёр, Тунисын хоёр, Бельгийн нэг, ОХУ-ын нэг, Канадын нэг, Кувейтын нэг, Сирийн нэг, израилын нэг иргэн тус тус амиа алдсан бол Туркийн 11 иргэн шинэ жилийн баяраа тэмдэглэхээр гэрээсээ гараад эргэж ирээгүй байна. Сири, Иракийн хойд хэсгийн ихэнх нутгийн хяналтдаа авч, улс байгуулснаа зарлаж байсан хэт даврагч “Лалын улс” бүлэглэл сүүлийн үед нөлөөллөө алдаж эхэлсэн.

Тус бүлэглэлийн эсрэг ОХУ болон Турк хамтран тэмцэхээ илэрхийлсэн юм. Улмаар үүний хариу болгон хэт даврагч бүлэглэл халдлага үйлдсэн байх магадлалтай билээ. Учир нь өнгөрөгч наймдугаар сараас эхлэн хэт даврагчдын эсрэг цэргийн ажиллагаа эрчимжсэн байдаг бөгөөд хэргээ хүлээсэн мэдэгдлийг хийх үедээ “Лалын улс” бүлэглэл агаарын бөмбөгдөлт, зэвсэгт дайралтуудын улмаас мусальман шашинтнуудын цус урсаж буйд Туркийг буруутгасан байдаг.

Франсуа Олланд Иракт айлчиллаа

Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд энэ сарын 2-нд Иракт айлчилжээ. Ирак дахь хэт даврагч бүлэглэлийн эсрэг АНУ тэргүүтэй холбоотны цэргийн эвсэл тэмцэж буй бөгөөд гол оролцогч улсын нэг нь Франц. Тиймээс ч, хэт даврагч бүлэглэлд элссэн алан хядагчид төрсөн нутагтаа эргэн ирээд халдлага үйлдэх вий гэдгээс хамгийн их болгоомжилж байгаа юм. Франсуа Олландын хувьд 2014 онд ч гэсэн Иракт айлчилж байсан удаатай. Мөн онд АНУ тэргүүтэй холбоотны цэргийн эвсэл байгуулагдсан бөгөөд түүнээс хойш Иракт айлчилсан цорын ганц гишүүн орны төрийн тэргүүн болж байна. Тэрбээр айлчлалын үеэр францын цэргийн армийнхан Иракийн цэргийнхний хамт бэлтгэл сургуулилтаа хийдэг цэргийн баазад зочилж, энэ үеэр “Иракт терроризмын эсрэг тэмцэж буй нь манай улсын бүрэн бүтэн байдлаа терроризмоос

хамгаалж буй нэгэн хэлбэр” гэдгийг онцолжээ. Ф.Олланд Иракийн Ерөнхийлөгч Фуад Масум, Ерөнхий сайд Хайдер аль Абади нарын хүмүүстэй албан ёсны уулзалт хийснийхээ дараа Курдын гол хот болох Арбил руу нисч, Курдын Засгийн газрын тэргүүн Массуд Базанитай уулзсан байна. Тэр үеэр Массуд Базани хэт даврагчдын гол түшиц цэг болж буй Мосул хотыг энэ зунаас өмнө чөлөөлнө гэх амлалтыг Францын төрийн тэргүүнд өгчээ. Энэ талаар Иракийг орхин эх орон руугаа нисэхээсээ өмнө Ф.Олланд мэдэгдсэн байна. Түүний хувьд 2017 оныг “терроризмын эсрэг ялалтын жил” болгон зарлахаар төлөвлөж буй ажээ. Гэвч, Ф.Олландын айлчилсан мөн өдөр Багдаад хотод террорист ажиллагаа болж, 32 хүн нас барж, 60 гаруй хүн гэмтсэн байна. Энэ халдлагыг “Лалын улс” үйлдсэн гэдгээ хүлээжээ.

“Үндэсний фронт” намын талаар кино хийгджээ

Энэ онд хэд хэдэн томоохон үйл явдал төлөвлөгдсөний нэг нь яах аргагүй Францын Ерөнхийлөгчийн сонгууль билээ. Энэ сонгууль ирэх дөрөвдүгээр сард орон даяар зохион байгуулагдах юм. Тэгвэл сонгууль болоход хэдхэн сарын хугацаа дутуу байхад хэт барууны Үндэсний фронт намын дарга Марине Ли Пенийг дүрсэлсэн кино баруунд бүтээгджээ. Тодруулбал, намын даргатай ижил дүр бүхий хэт үндсэрхэг үзлийн тухай өгүүлэх шинэ кино ирэх сард нээлтээ хийхээр болсон байна. Улмаар киног намын зүгээс эсэргүүцэн бухимдлаа илэрхийлж эхэлжээ. Бельгийн найруулагч Лукас Белваксын бүтээл “Chez nous” гэх кинонд Францын хойд этгээдэд амьдардаг өмгөөлөгч “Эх оронч эвсэл” гэх хатуу чиг шугамыг баримтлагч намаас сонгуульд нэр дэвшихээр болж буй талаар өгүүлэгдэх аж. Кинонд гарах зохиомол улс төрийн намын бодлого, зарчим болон Францын жүжигчин Катерин Иакобын бүтээсэн шаргал үстэй намын дарга бүсгүйн дүр нь “Үндэсний фронт” намыг санагдуулам байдлаар бүтээгджээ. Гэвч уг киног намын удирдах зөвлөлийн гишүүд эсэргүүцэж, сонгуулийн сурталчилгаа ид дундаа өрнөж байхад “Үндэсний фронт” намыг илт шүүмжилсэн утга агуулга бүхий киног дэлгэцнээ гаргах гэж буйг зөвшөөрч үл болно хэмээн эсэргүүцэх болсон байна.

Харин Бельгийн найруулагч эл хэргийн тухайд “FMTV” сувагт ярилцлага өгөхдөө намынхан уран бүтээлийг нь сонгуулийн хар пиар мэтээр хүлээж авч буйд гайхаж буйгаа илэрхийлээд амжжээ. Тэрбээр “Үндэсний фронт намын эсрэг кино гэхээсээ илүүтэйгээр популизм, хүмүүс улс төрд хэрхэн оролцож буйг харуулсан бүтээл. Миний хамгийн их сонирхож харуулахыг зорьсон зүйл бол сонгогчид. Харин нам биш” гэж хариулжээ. Францын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчид хэдийнэ тодорсон энэ үед томоохон хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн санал асуулгыг явуулж байна. Хамгийн сүүлийн санал асуулгаас үзэхэд ирэх тавдугаар сард болох шийдвэрлэх сонгуульд Үндэсний фронт намын дарга Ли Пен тунаж үлдэх магадлал өндөр байгаа. Гэхдээ Ерөнхийлөгч болохгүй бөгөөд хэт барууны үзэл баримтлалт нэр дэвшигч Франсуа Филлонд ялагдана гэсэн урьдчилсан төлөв ажиглагдаж байгаа юм байна.

УРИЛГА

БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага

-Компани татварын өргүй;
-Санхүүгийн чадамжтай;
-Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

Санал авах хугацаа

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг:
“Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, UBH центр, 8-р давхар
Улаанбаатар 14230
Утас: (976) 99140072
Факс: (976) 70106644
Вебсайт: www.mtz.mn

Монголын №1 FLEX GYM фитнес
төв нь үйл ажиллагаагаа өргөжүүлж ажлын байр шинээр бий болгож байгаа тул мэргэжил харгалзахгүйгээр маркетингийн менежер сургаж ажилд авна.
Цалин 1.000.000 сая төгрөг
Утас: 88111719, 99903191

Хүчингүйд тооцов

Самдангийн Чулуунбаатар /ФМ55053112/-ын Орхон аймгийн Баян-Өндөр сумын Согоот багийн 6-19-31 тоотод байрлах эрхийн улсын бүртгэлийн Y-2101011270 дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгов.

Цэнд овогтой Цээсүрэнгийн улсын бүртгэлийн ү-2205012633 дугаартай 0050297 тоот орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ гээсэн тул хүчингүйд тооцов.

ЦАГ YE

Аймгаас мэдээлж байна

ОРХОН АЙМАГ

ОРХОНЧУУД ОЛЗ ОМОГ ИХТЭЙ ШИНЭ ОНОО УГТАВ

Орон нутгийн бодлого шийдвэрээ "Хүний хөгжил"-д чиглүүлж буй Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут шаггүй удирдагч гэдгээ харуулж эхлээд байна. Ажлаа авсан даруйдаа л төрийн албан хаагчдыг хүнд сурталгүйгээр иргэдэд үйлчилж, бүр дэргэд нь оч гэдэг тушаалыг өгч, өөрөө араас нь очиж шалгаж эхэлсэн зангарагтай дарга бусад шигээ шинэ жил тэмдэглэж сүрийг үзүүлсэнгүй. Харин ч эдийн засгийн хямралтай энэ үед Засаг даргын нэрэмжит "Шинэ жилийн баяр"-ын хүлээн авалтыг хийхгүй хэмээгээд хэмнэсэн мөнгөөрөө 10 гэр худалдан авч гэнэтийн гамшиг ослын үед орон гэргүй болсон 10 айлд 20 сая төгрөгийн үнэ бүхий өргөө цагаан гэр бэлэглэсэн байна. Өргөө цагаан гэр хүлээн авсан айлууд нь 1-9 ам бүлтэй. Цагаанчулуут, Баянцагаан, Наран, Шанд, Дэнж, Уртын гол, Бүрэнбүст багийн өрхүүд бөгөөд тодорхой шалтгаанаар амьдралын боломж, нөхцөл нь муудсан эдгээр айлуудыг хүсэлт гаргасан 50 гаруй өрхөөс сонгож авсан ажээ. Шинэ оны эхэнд өргөө цагаан гэртэй болсон дээрх өрхийн гишүүд амьдрах итгэл, урам зориг авч буйгаа илэрхийлж аймгийн Засаг дарга, Тамгын газрын хамт олонд талархсанаа илэрхийлжээ. Угтаа бол өмнөх жилүүдэд Засаг даргын нэрэмжит "Шинэ жил"-ийн хүлээн авалтад орон нутгийн удирдлага болон "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн захирлууд оролцдог байсан боловч уг арга хэмжээг 2016 оноос эхлэн цуцлаж, түүнээс хэмнэсэн мөнгөөрөө нийгэмд хандсан бүтээлч ажил хийхээр шийдсэн гэнэ.

Түүнчлэн Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут, ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ш.Ганболд, Гадаад харилцааны мэргэжилтэн Ц.Ганбаяр, ИТХ-ын төлөөлөгч н.Чинзориг, Г.Эрдэнэбат нар оны төгсгөлд баярлаж, цэнгэж суухын оронд аймаг, орон нутгийнхаа хөгжлийн төлөө БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод албан айлчлал хийгээд иржээ. Орхон аймаг Манжуур хоттой 2015 оны дөрөвдүгээр сард "Санамж бичиг" байгуулсан байдаг бөгөөд энэ удаа хамтран ажиллах гэрээг үзэглэснээр хамтын ажиллагаа нь албан ёсоор нээгдэж байгаа нь энэ аж.

Манжуур хотын Намын хорооны дарга Чэнь Ли Шинь болон хотын удирдлагууд Орхон аймгийн зочид төлөөлөгчдийг хүлээн авч харилцан мэдээлэл солилцсоны дараа "Найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоох тухай" гэрээ байгуулсан аж. Ийнхүү Орхон аймаг гадаад харилцааны чиглэлээр 10 дахь хоттойгоо гэрээ байгуулж улмаар эдийн засаг, соёл урлаг, аж үйлдвэр, нийгмийн бүхий л салбарт хамтран ажиллах боломж бүрдэнэ. Дашрамд дуулгахад, Монгол Улсаас анх удаа Орхон аймаг Манжуур хоттой гэрээ байгуулж байгаа аж. 2017 оныг Орхончууд олз омог ихтэй угтлаа.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

323680 толгой мал тоологджээ

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2016 оны мал тооллогын дүнгээр 323680 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулбал 35317 толгой малаар буюу 12.2 хувиар өсчээ. Нийт тоологдсон малын 319.4 мянган толгой буюу 98.7 хувийг амины мал эзлэж байна. Улсын хэмжээгээр 61542.0 мян толгой мал тоологдсоноос 0.5 хувийг Дархан-Уул аймаг эзлэж байна. Малтай өрхийн 29.6 хувь нь 10 хүртэл, 38.9 хувь нь 11-100 хүртэл, 30.2 хувь нь 101-1000 хүртэл, 1.3 хувь нь 1000-аас дээш толгой малтай өрх байхад нийт малын 1.3 хувь нь 10 хүртэл, 12.0 хувь нь 11-100 толгой, 75.3 хувь нь 101-1000 хүртэл толгой малтай өрхөд ногдож байна. 1000-аас дээш толгой малтай 32 өрхөд 36365 толгой мал ногдож байгаа нь нийт малын 11.4 хувийг эзлэж байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудад адуу 223, үхэр 335, хонь 3118, ямаа 646 нийтдээ 4322 толгой мал тоологдсон ажээ. Малтай өрхийн тоо 2498 өнгөрсөн оныхоос 3.7 хувиар буюу 90 өрхөөр нэмэгдсэн байна. Малчдын тоо 2276 өнгөрсөн оны мөн үеэс найман хувиар буюу 168 малчнаар нэмэгдсэн байна. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо бод мал дээр гурав дахин алдагдсан байдалтай буюу нэг хуцанд 90 эм хонь, нэг ухнад 99 эм ямаа ногдож байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 12.8 мянган толгой, 1.6 мянган толгой мал зүй бусаар хорогдсон дүнтэй байна. Мөн гахай 48 өрх, нэг ААНБ-д нийт 1083 толгой гахай тоологдсон бол 147 өрх, хоёр ААНБ-д 17664 толгой шувуу, таван өрхөд 26 толгой туулай тоологдсон байна. Түүнчлэн зөгий бүлээрээ 81 өрх, гурван ААНБ-д тоологджээ. Худгийн тоо 749 өрх, есөн ААНБ-д 797 тооллогдсон бол малын хашааны тоо 2450 өрх, 21 ААНБ-д 3178 тоологдсон гэдэг мэдээллийг аймгийн Статистикийн хэлтсээс мэдээллээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

2017 оныг "Их бүтээн байгуулалтын жил" болгон зарлалаа

Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин 2016 оны долдугаар сарын 08-ны өдөр аймгийн Засаг даргын үүрэгт ажилд томилогдсон билээ. Үүнээс хойш олон ажлуудыг хийж хэрэгжүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалт бүрийг ирэх дөрвөн жилийн хугацаанд 100 хувь хэрэгжүүлэхээ илэрхийлсэн.

Тэгвэл Дорноговь аймаг 2017 оныг аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэн байгальд ээлтэй ногоон хөгжлийг дэмжих, гадаад харилцааг өргөжүүлэн хөрөнгө оруулалтын таатай, тогтвортой орчин бүрдүүлэн бүтээн байгуулалт, үйлдвэржилтийг эрчимжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж, иргэдийнхээ ая тухтай таатай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2017 оныг "Их бүтээн байгуулалтын жил" болгон зарлажээ.

ХЭНТИЙ АЙМАГ

Далд уурхай 6.0 сая дах тонн хүдрээ олборлов

Хэнтий аймаг дахь Бор-Өндөрийн далд уурхай 2003 онд 3.0 сая дахь тонн хүдрээ олборлож байсан бол 2016 онд 6.0 сая дахь тонн хүдэр гаргасан байна. Тус уурхай 1983 онд байгуулагдан, ашиглалтын хоёр босоо гол амаар олборлолт явуулж ирсэн бөгөөд уурхайгаас жилд 100.0 мян.тн хайлуур жоншны хүдэр олборлодог аж. Далд уурхай 2010 оныг хүртэл дөрөвдүгээр төвшинд буюу газрын гадаргаас 200 м-ийн гүнд олборлолт явуулж байсан бол өнөөдөр тавдугаар төвшинд, 250 м гүнд уурхайчид ажиллаж байна. Энэ онд зургадугаар хүдрийн биетийг нээн ашиглах бэлтгэл ажлыг ханган, зураг төслийг боловсруулаад байна.

ТӨВ АЙМАГ

Төв аймаг адуун сүргээр улсдаа тэргүүлэв

Мал тооллогын урьдчилсан дүн гарч Төв аймгийн хэмжээнд нийт 4.7 сая толгой мал тоолуулснаас 382 мянган толгой адуу тоолуулж адуун сүргээрээ улсдаа тэргүүлэв. Мал тооллогын урьдчилсан дүнгээр улсын хэмжээнд 61.5 сая толгой мал тоологдон дээд хэмжээндээ хүрсэн нь өмнөх оныхоос 5.5 сая толгой мал буюу 9.9 хувиар өссөн дүнтэй байна. Төв аймгийн хувьд нийт 4.7 сая мал тоолуулж улсдаа дөрөвдүгээрт бичигдсэн юм. Харин 330 гаруй сумаас Төв аймгийн Эрдэнэсант сум 414.8 мянган толгой мал тоолуулж улсын хэмжээнд дөрөвдүгээрт бичигдсэн амжилтаар шинэ онтой золголоо.

Мөн хоёр мянга дөрвөн зуун толгой хонь тоологдон улсын хэмжээнд хонин сүргээрээ гуравдугаарт бичигдэв. Түүнчлэн мал тооллогын 2016 оны дүнгээр сүрэгт хонины эзлэх хувь 0.7 хувиар өсөж үхэр ямааных 0.2-0.5 хувиар буурч, адуу тэмээний эзлэх хувь өссөн юм. Өнгөрсөн оны мал тооллогын эцсийн дүн нэгдүгээр сарын дундуур гарна гэдгийг Төв аймгийн Статистикийн газраас мэдээлсэн юм.

Асар бодлогоор хугацаанд Монголын топ сэтгүүлчдийн тэргүүн эгнээнд нэгдэж чадсан "PEOPLE of Mongolia" сэтгүүл шинэ оны босгон дээр **"PEOPLE AWARDS"**-ийг зохион байгуулж, анхны түүхэн номинацуудын эзэдийг тодрууллаа.

Улирал одсон 2016 оныг дүгнэж улс төр, бизнес, урлаг, спорт, энтертаймент, хүмүүнлэг гэсэн төрлүүдээр **"PEOPLE AWARDS"**-ийг зохион байгуулахдаа Монголын топ сайтууд болох Control.mn, Paparatsi.mn-ийг түшиглэн олон нийтийн дунд санал асуулга явуулж, мөн салбар хариуцсан яамд, төрийн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлт, мэргэжлийн экспертүүдийн судалгааг үндэслэн "People" сэтгүүлийн редакциас тодруулсан юм.

Сар бүр чанартай, давтгай сэтгүүлийг уншигчдынхаа гар дээр тавьдаг "People" нь 21-р зуунд нийгмийн бүх салбарт мэдлэгтэй, хөгжлийн түүчээ болон яваа хүчирхэг, агуу эрхмүүд, байгуулагуудаа урам зориг өгөхийн зорилгоор алдаршуулах нь хэвлэл мэдээллийнхэн бидний хувьд ч нийгмийн хариуцлагаа ухамсарлаж буй нэгэхэн хэрэг билээ. Энэ ч утгаараа нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, хүмүүнлэг үйлсэд гар бие оролцдог, тухайн онд салбартаа амжилт гаргасан эрхмүүдийг нэрлэж, хөхиүлэн дэмжиж ажиллахаа ийнхүү илэрхийлж байна.

Нэр хүндтэй эрэг хэмжээний үеэр дуучин Х.Менгенцацэг, Э.Болор-Уянга, "Ice top" хамтлагууд ая дуны мэдчилгээ ергөж, хурсан олны баясгасан билээ.

Дашрамд дурьдахад Монголын хамгийн залуу "PEOPLE" сэтгүүл нь сар бүр 5 000 хувиар хэвлэгдэж, дижиталаар тооцоор 30-40 мянга, жилдээ 500-600 мянган хүн унших боломж дуулгахад таатай байна.

Мэдээллийн эх сурвалж: "Өглөөний сонин", "Монголын үнэн", "Монголын мэдээ", "Монгол хүүдэн ямьдрал", "Сэрүүлэг" сонинууд, Control.mn, Paparatsi.mn, Mongolcomments.mn, Zaluu.com, Cask.mn, Tovchoo.mn, Breakingnews.mn, Zone.mn, Nuuts.mn, Ontslokh.mn, Shuurhai.mn, Bolod.mn, Fact.mn, Wikimon.mn, Times.mn, Inder.mn, Morningnews.mn, Shudarga.mn, 24 tsag.mn, ATG.mn, Todaynews.mn, Amjilt.com, Dorgio.mn, Info.mn, Urlag.mn, Zaluu.mn, Comment.mn.

Улс төр
1.Оны хамгийн нөлөө бүхий улстөрч-**М.Энхболд** /УИХ-ын дарга/
2.Эх орончЭ Түшээ-**Ж.Эрдэнэбат** /Монгол Улсын Ерөнхий сайд/
3.Оны онцлох эмэгтэй улстөрч-**Д.Оюунхорол** /БОАЖ-ын сайд, УИХ-ын гишүүн/
4.Оны Шилдэг сайтай улстөрч-**Г.Менхбаяр** /БХБ-ын сайд/
5.Түшиглэгч төрийн түшээ-**Д.Очирбат**
/Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/
6.Оны Зангараг-тай улстөрч-**С.Эрдэнэ** /УИХ-ын гишүүн/
7.Оны иргэний зоригтой улстөрч-**Н.Алтанхуяг** /УИХ-ын гишүүн асан/
8.Төр, түмэндээ эзэлтэй улстөрч-**Г.Батхүү** /УИХ-ын гишүүн асан/
9.Олноо хүндлэдэг улстөрч-**З.Нарантуяа** /УИХ-ын гишүүн/
10.Иргэдийн итгэл хүлээсэн залуу улстөрч-**С.Эрдэнэтуул**
/Үндэсний цацраг-лэгт хүрээлэнгийн захирал/
11.Оны хөшигний ардах сэрэг хүн-**Ц.Энбагдорж** /Монгол Улсын Ерөнхийлөгч/

Бизнес
1.Үндэсний Шилдэг санхүүжүүлэгч-**Худалдаа хөгжлийн банк**
2.Оны Эх орончЭ бизнесмэн-**Т.Ариунболд** "Алтан Дорнод Монгол"
3.Оны Шилдэг бүтээн байгуулагч компани-**"Хотолийн Цемент-Шохой" ХК**
4.Оны Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч,
Үүл уурхайн шилдэг компани-**"Болдтөмөр Ерөө гол" ХХК**
5.Оны Шилдэг, шинэлэг технологи нэвтрүүлэгч-
"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК
6.Үндэсний Шилдэг татвар төлөгч-**"Эрдэнэт үйлдвэр" ХХК**
7.Оны Хамгийн нэр хүндтэй, иргэдийн итгэл хүлээсэн,
шударга байгууллага-**"Начин заан" ХХК**
8. Оны шилдэг залуу Бизнес хатагтай-**Э.Халиун** "Super Rubin" компанийн захирал
9.Оны Бариулын салбарын шилдэг компани- **"ББСМО"** зураг төслийн компани
10.Эрүүл мэндийн салбарын шилдэг байгууллага-**"Гранд Мед" Эмнэлэг**
11.Оны Аялал жуулчлалын шилдэг байгууллага-**"Нью Жуулчин Турс" ХХК**

Хүмүүнлэг, Энтертаймент
1.Оны Хүмүүнлэгийн үйлстэн-**Г.Ундармаа**
2.Оны сайн үйлстэн-**Б.Зулаа** /"Хос билгүүн зуг" ХХК-ийн захирал/
3.Оны Хамгийн сайхан, улгэр жишээ гэр бүл-**"Макс" Д.Ганбаатарын гэр бүл**
4.Оны оны таашаалд хамгийн их нийцсэн бренд-**"Sherri Hill" Mongolia**
5.Оны Хамгийн сайхан бие аяг ядаг хатагтай-**П.Анужин**
6.Оны жентелмэн-**У.Хүрэлсүх** /Монгол Улсын Шадар сайд/
7.Оны Соёл-ын ертөнцийн од-**Ц.Цогтбаяр, Б.Баяраа** /Дасгалжуулагчид/
8.Оны дур булаам хатагтай-**Ч.Дэлгэрцацэг** /Хөгжим/
9.Оны гуущдаа тэмцэгч-**Ц.Тунацэцэг**
/Монголын байгаль орчны төлөөх хүүхэдтэй холбоотой дэд тэргүүн/

NO STRESS

ФОТО УРЛАГ

Шинэ оны анхны нар мандлаа

2017 оны нэгдүгээр сарын 01. 08.33 цагт

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр -12
Шөнө -21

Нөгөөдөр

Өдөр -11
Шөнө -23

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.42-17.13
Үс засуулбал: Өнгө зүс сайжирна

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, гарагийг тахих, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлжлэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

ОДДЫН АМЬДРАЛ

Анжелина Жоли Колорадод шинэ оноо өнгөрүүлжээ

10 гаруй жил хамтран амьдарсны эцэст хуримласан холливудын алдарт жүжигчин Брэд Питт, Анжелина Жоли нар өнгөрсөн оны есдүгээр сард салж буйгаа зарласан. Түүнээс хойш хүнд байдалд байгаа гэх жүжигчин бүсгүй шинэ жилээ Колорадод өнгөрүүлжээ. Тэрбээр 2016 оны төгсгөлд дөрвөн сая ам.долларoор харш түрээсэлж, хүүхдүүдийнхээ хамт цанаар гулгах баярласан байна. Эдүгээ 41 настай тэрбээр өөрийн өргөмөл нийлсэн зургаан хүүхдээ өөр дээрээ өсгөнө гэдгээ мэдэгдээд буй. Түүнд 15 настай Маддокс, 13 настай Пакс, 11 настай Захара, 10 настай Шилох, найман настай Кнокс, Вивиэн нарын зургаан хүүхэд бий. Тэгвэл бүсгүй тэдний гуравтай нь хамт цанаар гулгаж буй зурагт шар сайтуудад нийтлэгджээ.

Кайли Женнер найз залуудаа зориулан шинэ шивээс хийлгэжээ

Реалити шоуны од Кайли Женнер найз залуудаа зориулан шинэ шивээс хийлгэжээ. Телевизийн шоугаар танигдаж, өсвөр насны охидын шүтээн болсон бүсгүй эдүгээ 19 настай бөгөөд реппер Тайгатай 2014 оны аравдугаар сараас эхлэн болзож эхэлсэн байдаг. Хосууд өнгөрсөн жил нэг удаа салах дөхсөн ч, удалгүй эргэн нийлж, түүнээс хойш олон цагийг хамтдаа өнгөрүүлж буй. Тэгвэл хайртдаа зориулж Кайли саяхан хөлийнхөө шагайн орчимд жижиг шивээс хийлгэсэн гэнэ. Энэхүү шивээс нь жижиг "Т" үсэг бөгөөд Тайгагийн нэрний эхний үсэг хэмээн эх сурвалжууд мэдээлж байна.

ХӨЛБӨМБӨГ

Витцель Хятадын багаас 4 жилд 80 саяыг авна

Италийн "Ювентус" руу явахаар ярьж байсан Бельги хөлбөмбөгч Аксел Витцел Хятадын "Тяньжин Цюаньцзянь" багт очсон билээ. Тэгвэл түүний цалин мөнгөтэй холбоотой зарим нэг мэдээлэл тодорхой болжээ. Tuttomercatoweb-ийн мэдээлж байгаагаар өдгөө 27 настай хөлбөмбөгч Хятадын багтай дөрвөн жилийн гэрээ байгуулсан байна. Тэрбээр Хятадын клубээс жилдээ урамшуулалтайгаа нийлээд 15.5 сая еврогийн цалин авах аж. Үндсэндээ дөрвөн жилийн хугацаанд жилдээ 13-15 саяын цалин авах юм байна. Ингэхээр гэрээний хугацаанд нийтдээ 80 сая еврогийн цалин авах нь.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Orlomjav Tseedorj



Манай нөхөр өөр хүүхэнтэй хөтөлцөөд надаас ум хумгүй зугатаад би нь араас нь хашгичаад л хөөгөөд... цочоод сэрээд хартал хажууд сайхан нам унтаж байдиймдаа. Нэг сайн алгадаад авсаан ккк. Цочиж сэрээд гайхаад зүүдээ яриад бөөн инээдэм ккк

TENGIS MOVIE THEATRE

Аз жаргал, зовлон гуниг, хайр дурлал, хардалт, амжилт, бүтэлгүйтэл гээд л хар, цагаан хосолж байдаг хүний амьдралд бид төрөхдөө "Амьдралын сурах бичиг"-ээ өвөртлөөд ирдэг бол хичнээн сайхан! Өөрийн биеэр туулж байж л амьдралын зах зухаас мэдэж, сурч, туршлагажиж ухаардаг. Энэ бол "Амьдралоги" юм. Тэгвэл амьдралынхаа 2 дахь үеийн хямралд орсон гэр бүлийн хос, амжилттай яваа ч заяаны ханиа хараахан олоогүй бүсгүй, залуу халуун насныхаа алдаа, оноог дэнслүүлэн яваа оюутан охин болон киноны бусад дүрүүдийн аз жаргалын төлөөх тэмцэл болон тэдний санаанд оромгүй сонголтуудыг "Амьдралоги" романтик инээдмийн уран сайхны киноноос үзээрэй.



Assassin's Creed буюу Алуурчны үнэмшил видео тоглоомоос сэдэвлэн бүтээв.



Жазз хөгжимчин Сибастиан жүжигчин болох хүсэл мөрөөдөлтэй Миа бүсгүйд дурлана. Миа киноны шалгаруулалтуудад орохын хажуугаар кино одуудад кофе зөөдөг бол жазз хөгжимчин Сибастиан ядруухан баранд коктэйлний үдэшлэгийн хөгжим тоглож амь зогоодог байв. Амжилтад ойртохын хэрээр тэд тэдний эмзэгхэн хайрыг сэвтээх хүнд шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болно.